



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2024/06/НА-СТА-ОНӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2024 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342716 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

“БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ГАНБААТАР
ТАНАА

2024.03.15 № 318
танай _____ ны № _____ Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Булган Мээж” ОНӨХХК-ий 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Булган Мээж” ОНӨХХК-ий 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Б/10 дугаар захирамжаар тус компанийн гүйцэтгэх захирлыг томилсон байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 2023 оны XV/01 тогтоолоор Булган Мээж ОНӨХХК-ий төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 7 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Тайлант онд “Энержи плас” ХХК-тай холбоотой дулааны үнийн өглөг 2,236.3 сая төгрөгөөр нэмэгдэж, жилийн эцсийн байдлаар 6,278.7 сая төгрөгийг үлдэгдэлтэй болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 618 дугаар

000020736

тогтоолоор "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713" төслийн хүрээнд бий болсон 10,498.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн,

Булган аймгийн ИТХ-ын XIX/13 дугаар тогтоолын дагуу 151,172.7 мянган төгрөгийн автомашиныг данснаас хасаж 2-догч түүхий эд болгон худалдахаар данснаас хассан

Бусад асуудлын хэсэг

"Булган Мээж" ОНӨХХК-ий гүйцэтгэх захирал аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 4 зорилт 26 арга хэмжээ төлөвлөснийг 87.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

2023 онд дулаан борлуулалттай холбоотой 5,149.1 сая төгрөгийн орлого олж, 555.8 сая төгрөгийн авлага үүсэж, дулаан борлуулалттай холбоотой үйл ажиллагааны зардалд 970.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

ТУЗ-ын 2023 оны 12 дугаар тогтоолоор 2021 онд халаалтын үнэ нэмсэнтэй холбоотой авлагаар бүртгэсэн 39 төсөвт байгууллагын 182.3 сая төгрөгийг авлагыг хасаж тайланд тусгасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2023.01.01	2023.12.31
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	165,098,798.33	326,003,766.40
2	Дансны авлага	756,770,528.27	1,025,415,309.59
3	Татвар, НДШ-ийн авлага	375,311,394.68	492,173,150.12
4	Бусад авлага	73,057,863.68	173,864,846.69
5	Бараа материал	7,066,093,908.47	420,627,159.87
6	Бусад эргэлтийн хөрөнгө	42,348,935.36	25,000,000.00
7	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,478,681,428.79	2,463,084,232.67
8	Үндсэн хөрөнгө	11,170,647,541.00	25,384,822,306.15
9	Биет бус хөрөнгө	3,000,000.00	51,501,725.32
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,173,647,541.00	25,436,324,031.47
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,652,328,969.79	27,899,408,264.14
12	Дансны өглөг	4,045,053,174.80	6,284,666,516.19
13	Татварын өр	206,321,602.55	197,775,134.19
14	Урьдчилж орсон орлого	5,056,226.05	10,288,834.62
15	Нөөц /өр төлбөр/	4,813,157.00	4,813,157.00
16	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,261,244,160.40	6,497,543,642.00
17	Урт хугацаат зээл	10,219,647,991.55	13,929,064,619.65
18	Нөөц /өр төлбөр/	136,309.09	136,309.09
19	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,219,784,300.64	13,929,200,928.74
20	Өр төлбөрийн нийт дүн	14,481,028,461.04	20,426,744,570.74
21	Өмч: - төрийн	10,132,903,076.15	14,725,436,872.77
22	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	381,177,427.96	381,177,427.96
23	Хуримтлагдсан ашиг	(5,342,779,995.36)	(7,633,950,607.33)
24	Тайлангийн үеийн ашиг	-	(2,108,821,517.82)
25	Өмнөх үеийн ашиг	(5,342,779,995.36)	(5,525,129,089.51)
26	Эздийн өмчийн дүн	5,171,300,508.75	7,472,663,693.40
27	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,652,328,969.79	27,899,408,264.14

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,117,598,426.29	6,333,904,847.12
2	Борлуулалтын өртөг	8,120,945,718.22	8,585,288,061.55
3	Нийт ашиг(алдагдал)	2,003,347,291.93	-2,251,383,214.43
4	Түрээсийн орлого	5,312,000.00	14,456,852.73
5	Хүүгийн орлого	6,041,661.50	12,836,660.15
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	558,619,024.54	844,142,918.80
8.1	Орлогын дүн	569,972,686.04	871,436,431.68
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	380,960,178.89	396,965,467.43
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	23,970,056.30	235,293,444.96
12.1	Зардлын дүн	404,930,235.19	632,258,912.39
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-2,013,888.82	-528,333.04
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	-81,429,900.97	-96,087,489.64
17.1	Олз, гарзын дүн	-83,443,789.79	-96,615,822.68
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,921,748,630.87	-2,108,821,517.82
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
2.1.2.6	05-Бусад орлого	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,921,748,630.87	-2,108,821,517.82
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,921,748,630.87	-2,108,821,517.82
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	7,729,781,236.18	3,405,914,717.21	6,265,957,588.30
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-15,116,647.28	-15,116,647.28
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	1,921,748,630.87	1,921,748,630.87
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	842,208,198.60	0.00	842,208,198.60
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	8,571,989,434.78	5,342,779,995.36	5,171,300,508.75
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-182,349,094.15	-182,349,094.15
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	2,108,821,517.82	2,108,821,517.82
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	4,592,533,796.62	0.00	4,592,533,796.62
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	13,164,523,231.40	7,633,950,607.33	7,472,663,693.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,205,659,023.58	7,575,909,397.19
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,619,331,795.74	7,107,112,429.52
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	253,435,182.66	322,670,870.14
1.1.6	Бусад мөнгөн орлого	332,892,045.18	146,126,097.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,161,996,135.39	7,193,316,539.27
1.2.1	Ажиллагчдад төлсөн	862,275,019.43	905,411,477.23
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	229,388,045.02	317,442,572.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	370,002,731.77	1,102,352,528.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,018,792,084.61	4,042,781,107.28

1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	173,125,623.00	371,821,500.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	318,111.30	1,411,784.33
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	217,591,554.84	269,661,397.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,269,337.00	367,424.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	289,233,628.42	182,066,748.35
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	43,662,888.19	382,592,857.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	12,836,660.15
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	12,836,660.15
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	40,797,125.00	234,524,550.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	40,797,125.00	234,524,550.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-40,797,125.00	-221,687,889.85
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,865,763.19	160,904,968.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162,233,035.14	165,098,798.33
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,098,798.33	326,003,766.40

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйц	2023 он				2022 оноос	
				Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
1	Шугам хоолойн цэвэр ус	мян.м3	109.1	102.87	106.9	4.03	103.9	-2.2	86.9
2	Бохир ус татан зайлуулах	мян.м3	152.3	86.34	87.9	1.56	101.8	-64.4	71.2
3	Тээврийн цэвэр ус	мян.м3	15.4	14.02	15.5	1.48	110.6	-0.1	121.3
4	Түгээсэн дулаан	мян.гкал	38.2	36.5	38.9	-2.4	106.6	-0.7	119.7

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 9.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Захирлын 2022 оны А/17 дугаар тушаалаар баталсан захирлын зөвлөлийн ажиллах журмын 2.10- д "зөвлөлийн гишүүдэд сар бүр 100,000 төгрөгийн урамшуулал олгоно." гэж заасан ч 4 дүгээр сард гүйцэтгэх захиралд 300,000 төгрөгийн зөвлөлийн нэмэгдлийг олгосон байна.

5.2 Албан шаардлага

Могод сумын Тээг багийн Зүр үзүүрийн гармын Орхон голын эрэг дээрх тавцант, гатлагат онгоцыг ажилуулахаар иргэн Г.Батзоригтой гэрээ хийсэн байна. Гэрээнд эвдрэл засвар үйлчилгээг захиалагч тал хариуцан гарсан зардал дээр ажилласан хугацааны ашгийн 10 хувь нэмж төлөхөөр гэрээ байгуулсан ч тайлант онд үйлчилгээ үзүүлсэн бүртгэл орлогын тооцоо байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага өгөх.

Цемент шохой ТӨХК-аас 1000 шуудай буюу 50 тн цемент авч жилийн эцсийн байдлаар бараа материалын дансанд 559 шуудай 27.9 тн хэрэгцээ шаардлага нь тодорхойгүй материал нөөцөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн материалын дансанд 6 нэр төрлийн 1,302,312 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Захирлын 2022 оны А/17 дугаар тушаалаар баталсан захирлын зөвлөлийн ажиллах журмын 2.10- д "зөвлөлийн гишүүдэд сар бүр 100,000 төгрөгийн урамшуулал олгоно." гэж заасан ч 4 дүгээр сард гүйцэтгэх захиралд 300,000 төгрөгийн зөвлөлийн нэмэгдлийг олгосон байна.	1	300.0	1	300.0								
Могод сумын Тээг багийн Зүр үзүүрийн гармын Орхон голын эрэг дээрх тавцант, гатлагат онгоцыг ажилуулахаар иргэн Г.Батзоригтой гэрээ хийсэн байна. Гэрээнд эвдрэл засвар үйлчилгээг захиалагч тал хариуцан гарсан зардал дээр ажилласан хугацааны ашгийн 10 хувь нэмж төлөхөөр гэрээ байгуулсан ч тайлант онд үйлчилгээ үзүүлсэн бүртгэл орлогын тооцоо байхгүй байна.					1	0						
Аж ахуйн материалын дансанд 6 нэр төрлийн 1302312 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.							1	1302.3				
Дүн	3	1602.3	1	300	1	0	1	1302.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв мэдээлээгүй, тайлант онд 7 мэдээлэл хугацаа хоцроож	1	0					1	0

мэдээлсэн байна.								
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цемент шохой ТӨХК-аас 1000 шуудай буюу50 тн цемент авч жилийн эцсийн байдлаар бараа материалын дансанд 559 шуудай 27.9 тн хэрэгцээ шаардлага нь тодорхойгүй материал нөөцөлсөн байна.	1	9765.0			1	9765.0		
Дүн	1	9765.0			1	9765.0		
Нийт дүн								